



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/690

Номгон

Гамшгаас хамгаалах дадлага, сургууль
зохион байгуулах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн сургууль”-ийг Баян-Өндөр, Гурванбулаг, “Команд штаб”-ын сургуулийг Бууцагаан, Баянговь, сумдад аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах “Бэлэн байдлын үзлэг”-ийг Хүрээмарал, Богд сумдад тус тус зохион байгуулсугай.

2. Гамшгаас хамгаалах дадлага, сургууль, аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулах хуваарийг 1 дүгээр, шаардагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Гамшгаас хамгаалах дадлага, сургууль аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт шаардагдах 6.000.000 (зургаан сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавь ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХСАЙХАН

601210611